

ЭРДЭНЭ РЕСУРС НЬ ХАР МОРЬ ТАЛБАЙД 5.86 Г/Т АЛТНЫ АГУУЛГА БҮХИЙ 27 МЕТР, 5.63 Г/Т АЛТНЫ АГУУЛГА БҮХИЙ 30 МЕТРИЙН ИНТЕРВАЛ ОГТОЛЛОО

Хэвлэлийн мэдээ
Нова Скошиа муж, Халифакс хот
2021.07.27

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX: ERD | MSE: ERDN) (“Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани”) нь өөрийн 100% эзэмшил бүхий Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд нээн илрүүлсэн Хар Морь талбайн 2021 оны 2-р улирлын өрөмдлөгийн үр дүнг танилцуулахад таатай байна.

Онцлох мэдээлэл

- Баян Хөндий алтны ордоос хойш 3.5 км-т орших Хар Морийн Дэл бүсийн өмнө хэсэгт судлын дагуу доош уналттай эрдэсжсэн бүсэд хэд хэдэн цооногт өндөр агуулгатай (≥ 1 г/т алт) эрдэсжилтийг огтоллоо:
 - AAD-124 цооногийн 24 метрээс эхлэн 5.86 г/т алтны агуулга бүхий 27 метр интервал огтолсон бөгөөд түүнд цооногийн 28 метрээс эхэлсэн 17.41 г/т алтны агуулга бүхий 3 метрийн интервал багтаж байна.
 - AAD-126 цооногийн 10 метрээс эхлэн 5.63 г/т алтны агуулга бүхий 30 метрийн интервал огтолсон бөгөөд түүнд цооногийн 26 метрээс эхэлсэн 24.12 г/т алтны агуулга бүхий 6 метрийн интервал багтаж байна.
 - AAD-123 цооногийн 58 метрээс эхлэн 2.86 г/т алтны агуулга бүхий 30 метрийн интервал огтолсон бөгөөд түүнд цооногийн 61 метрээс эхэлсэн 7.03 г/т алтны агуулга бүхий 11 метрийн интервал багтаж байна.
 - Энэхүү хөтөлбөрийн хүрээнд өрөмдсөн 23 цооногийн 20 цооногт аномаль алтны эрдэсжилт огтлогдсон (≥ 0.1 г/т алт).
- Хар Морийн Дэл талбайн өмнөд хэсэгт орших энэхүү өндөр агуулга бүхий бүс нь трендийн дагуу 50 метр өргөн, 180 метр суналтай, гүндээ нээлттэй байна.
 - AAD-130 цооног нь өндөр агуулгатай эрдэсжсэн бүсийг суналын дагуу урд зүг рүү 65 метр тэллээ.

Тодруулга

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч бөгөөд гүйцэтгэх захирал Петер Акерли хэлэхдээ “Баян Хөндий алтны ордоос хойд зүгт 3.5 км-т орших энэхүү өндөр агуулга бүхий, газрын дөт гүнд орших, исэлдсэн хүдэр бүхий алтны онцгой үр дүнгүүд нь уурхайн

бүтээн байгуулалтад дэмжлэг болохоос гадна Хөндий Алтны Дүүргийн хэтийн төлөв, боломжуудыг илэрхийлж байна. Хар Морийн Дэл талбайн өмнөд бүс нь Баян Хөндий орчмын гол эрдэсжилттэй холбоотой томоохон структурын трендтэй холбогдож байна.”

“Хөндий Алтны Дүүргийн хайгуулын ажил үргэлжилж байгаа бөгөөд Баян Хөндий алтны ордоос баруун зүгт 400 метрт орших Улаан талбайн алтны эрдэсжилтийг судлах анхан шатны өрөмдлөгийн үр дүн хүлээгдэж байна. Манай баг 3-р улиралд 1.4 км үргэлжлэх Хар Морийн Дэл бүсэд хийгдэх илүү гүн өрөмдлөгийн хөтөлбөрийг тодорхойлох нарийвчилсан геофизикийн ажлыг ирэх долоо хоногуудад эхлүүлэхээр ажиллаж байна.”

Өрөмдлөгийн хөтөлбөрийн хураангуй

Хар Морийн Дэл бүсийн эрдэсжилтийг тодорхойлох өрөмдлөгийн хөтөлбөрөөр нийт 2,053 метрийн турш 23 ширхэг гүехэн цооног өрөмдсөн. Цооногуудыг 30-50 метрийн зайтай төлөвлөсөн ба газрын дөт гүнд, өндөр агуулга бүхий исэлдсэн эрдэсжилтийн бүсийг шалгав.

Энэхүү өрөмдлөгөөр Хар Морийн Дэл бүсийн өмнөд төгсгөлөөс алтны эрдэсжсэн бүс тасралтгүй үргэлжилж байгааг амжилттай тодорхойлсон бөгөөд энэ бүс нь өндөр агуулга бүхий суналын дагуу үргэлжлэх 180 метрийг (1 г/т-оос их) багтаан, суналын дагуу ойролцоогоор 350 метр тэлэн үргэлжилж байна. Хар Морийн Дэл нь гүндээ нээлттэй байгаа бөгөөд ирээдүйн өрөмдлөгийн хөтөлбөрөөр илүү гүний өрөмдлөг хийнэ.

Геологийн хувьд Хар Морийн Дэл талбайн өндөр агуулга бүхий бүс нь эпитеpmаль системийн онцлог болох бага температурт цагаан гялтгануур шаварлагийн хувирлаар давамгайлсан өргөн тархсан туфтай холбоотой. Туфийн алтны агуулга нь хойд ба өмнөд, зүүн хойд структурын огтлолын цэгүүдтэй холбоотой исэлдэл болон хугарлын хуримтлал бүхий бүсэд баяжсан хандлагатай байна. Хар Морийн Дэл дээр хийсэн соронзон геофизикийн судалгааны үр дүнд хувирсан ба эрдэсжсэн агуулагч туф болон бага далайцын соронзон тэмдэглэлийн хүчтэй хамаарал байгааг тодорхойлсон. Соронзон өгөгдлийн 3 хэмжээст загварчлалаар судалгаа хийгдээгүй хэд хэдэн хэтийн төлөв бүхий талбайд соронзон нам тэмдэглэл гүндээ тасралтгүй үргэлжилж байгааг илрүүлсэн.

Хар Морийн Дэл талбайн өмнөд бүсийн өрөмдлөгийн ажлын үр дүнг Хүснэгт 1-т тоймлон харуулав. Цооногийн байршлыг харуулсан план зураглал болон хөндлөн зүсэлтийн зурагтай хавсралтаас танилцана уу (Зураг 2 ба 3).

Хүснэгт 1: Хар Морийн Дэл (өмнөд) талбайн 2021 оны 3-р улирлын өрөмдлөгийн онцлох үр дүнгүүд (Бүх интервалууд дунджаар 0.30 г/т алтнаас өндөр агуулгатай)

Цооног	м-ээс	м хүртэл	Интервал ⁽¹⁾	г/т алт
AAD-120	83	84	1	0.67

Ба	178	180	2	0.37
AAD-121	38	40	2	0.46
Ба	48	58	10	1.01
AAD-122	80	85	5	2.13
AAD-123	58	88	30	2.86
Түүнд	61	72	11	7.03
Түүнд	63	64	1	17.59
түүнд	67	68	1	16.50
AAD-124	18	19	1	1.74
Ба	24	51	27	5.86
Түүнд	28	31	3	17.41 ⁽²⁾
Түүнд	33	34	1	14.03
Түүнд	37	38	1	25.37
Түүнд	42	43	1	10.08
Түүнд	46	47	1	11.51
Ба	60	61	1	0.36
AAD-125	65	72	7	3.65
Ба	100	101	1	0.32
AAD-126	10	40	30	5.63
Түүнд	21	33	12	13.38
Түүнд	26	32	6	24.12 ⁽³⁾
AAD-127	60	67	7	2.33
Түүнд	65	66	1	10.24
Ба	71	72	1	6.22
AAD-128	38	39	1	0.47
Ба	47	51	4	0.58
Ба	55	63	8	0.36
AAD-129	4	37	33	2.05
Түүнд	14	26	12	5.07
Түүнд	17	18	1	38.44
AAD-130	9	45	36	1.39
Түүнд	23	40	17	2.46
Түүнд	24	25	1	10.74
AAD-132	42	53	11	0.54
AAD-133	3	4	1	0.31
Ба	11	18	7	0.32
Ба	20	21	2	0.42

1. Тайлагнасан интервал нь цооногийн огтлолын зузаан болно. Нэмэлт хайгуул хийснээр бодит зузаан болон эрдэсжилтийн анизотропыг тодорхойлох боломжтой.

2. >10 г/т алтны агуулга бүхий гурван зэргэлдээ дээж багтсан. Үүнд 13.78-аас 21.71 г/т алтны агуулга бүхий дээжүүд багтаж байна.

3. >10 г/т алтны агуулга бүхий зургаан зэргэлдээ дээж багтсан. Үүнд 13.97-аас 36.49 г/т алтны агуулга бүхий дээжүүд багтаж байна.

Дээрх үр дүнгэс гадна Хар Морийн Дэл структурын хойд хэсэгт хийсэн өрөмдлөгөөр газрын дөт гүнд алтны исэлдсэн эрдэсжилт огтолсон. Хар Морь талбайн алтны

эрдэсжилт нь хувирсан туф ба холбогдох соронзон нам шинж чанартай холбоотой. Соронзон нам нь гүн рүү сунаж, судлагдаагүй хэвээр байна. Хойд бүсэд хийсэн өрөмдлөгийн цооногуудын үр дүнг Хүснэгт 2-т танилцуулав.

Хүснэгт 2: Хар Морийн Дэл (Хойд) Q3 2021 оны 3-р улирлын өрөмдлөгийн хөтөлбөрийн онцлох үр дүнгүүд (Бүх интервалууд дунджаар 0.30 г/т алтнаас өндөр агуулгатай)

Цооног	м-ээс	м хүртэл	Интервал ⁽¹⁾	г/т алт
AAD-112	58	60	2	0.39
Ба	98	100	2	0.48
Ба	104	131	27	0.51
AAD-113	75	101	26	0.66
Түүнд	77	87	10	1.35
AAD-114	16	22	6	0.74
AAD-115	21	30	9	0.29
Ба	58	76	18	0.33
AAD-116	1	11	10	0.49
AAD-117	22	48	26	0.35
AAD-118	19	42	23	0.39

1. Тайлагнасан интервал нь цооногийн огтлолын зузаан болно. Нэмэлт хайгуул хийснээр бодит зузаан болон эрдэсжилтийн анизотропыг тодорхойлох боломжтой.

Ирээдүйн төлөвлөгөө

Энэхүү өрөмдлөгийн хөтөлбөрийн үр дүн болон өнөөг хүртэл хийсэн хайгуулын үр дүнгүүдээс харахад Хөндий Алтны Дүүргийн нийт талбайд хэд хэдэн эпитеpmаль алтны эрдэсжилт бүхий бүсүүдийг агуулж байгааг баталж байна. Ерөнхийдөө андезит найрлагатай болон дэд галт уулаас туффакийн нэгж хүртэл галт уулын литологи нь алтны томоохон эрдэсжилттэй холбоотой бага температур бүхий эпитеpmаль хувирлаар дарагдан, өндөр температурт үйл явцын хүрээнд гидротермик байдлаар хувирсан. Энэхүү төрлийн орчин, структур нь эрдэсжсэн шингэн, алтны эрдэсжилтийг төвлөрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Геофизикийн судалгаа нь гидротермаль хувирлын структур болон бүсийг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх бөгөөд хэтийн төлөв бүхий өрөмдлөгийн бүсүүдийг тодорхойлох чухал хэрэгсэл болно. Хийгдэж буй өрөмдлөг бүр нь Компанийн геологийн загварчлалыг сайжруулан, ирээдүйн өрөмдлөгийн хөтөлбөрийг чиглүүлэх ач холбогдолтой.

Алтан Сум талбайг оролцуулан Хар Морийн нөөцийн тооцооллыг боловсруулах зорилтын хүрээнд Компани нь гүний боломжуудыг судлан эрдэсжилтийг тэлэх, баталгаажуулах ирээдүйн өрөмдлөгийн хөтөлбөрт чиглэн ажиллана. Гүний бүсүүдийг тодорхойлоход дэмжлэг үзүүлэхээр соронзон-теллурт дуу авианы цогц үүсгүүр (CSAMT) болон нарийвчилсан диполь-диполь туйлшралын (Dp-Dp IP) аргуудыг ашиглан геофизикийн судалгааг хийж гүйцэтгэхээр ажиллаж байна. Энэхүү судалгааг Хар Морь талбайн 4 км² бүсэд гүйцэтгэх бөгөөд судалгаа нь эпитеpmаль үүсэлтэй судлын системүүдтэй холбоотой цахиуржилт болон шаврын хувирлыг илэрхийлэгч чулуулгийн цахилгаан эсэргүүцэх, дамжуулах чадварын

бүсүүдийг тодорхойлоход оршино. Үр дүнг геохими, структур ба соронзон өгөгдөлтэй хамт геологийн загварчлалын програмд оруулан, зорилтот талбайд газрын дөт гүнд болон гүн рүү өрөмдөх цооногуудыг тодорхойлно.

Хар Морь талбайн тухай

Компани нь 2019 оны 8 дугаар сард Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн урьд нь судалгаа хийж байгаагүй хэсэгт Хар Морь талбайг Баян Хөндий ордоос хойш 3.5 км газарт нээн илрүүлсэн. 2019 оны эцсээр гадаргуун хайгуулын ажил гүйцэтгэсэн, үүнд геологийн зураглал, геохимийн судалгааг (чулуун болон хөрсний дээжлэлт) хийсэн бөгөөд хэд хэдэн чулуун дээжид буюу сиенитийн порфирийг зүссэн комб кварц-адулярын судалд 5 г/т-оос 87.8 г/т хүртэлх алтны агуулга илэрсэн. 2020 оны 6 дугаар сард Компани нь Хар Морь талбайд үргэлжлүүлэн суваг малталт хийж, сорьцлолтын үр дүнд 8.8 г/т алтны агуулга бүхий 6 метрийн интервал огтлолцол, үүнд 50.8 г/т алтны агуулгатай 1 метрийн интервал огтлолцол болон 14 г/т алтны алтны агуулга бүхий 4 метрийн интервал огтлолцол илрүүлсэн. Хар Морь хэтийн төлөв бүхий талбайд анхны буюу 25 цооногоос бүрдэх нийт 4,660 метрийн өрөмдлөгийн ажлыг 2020 оны хоёрдугаар хагаст хийж дуусгасан. Хайгуулын хөтөлбөрийн үр дүнд Хойд-Урд тренд, 1.4 км урт үргэлжилсэн эрдэсжилтийн структурыг тодорхойлсон, үүнийг Хар Морь талбайн Дэл бүс гэж нэрлэсэн ба Хар Морь талбай нь Баян Хөндий алтны ордын нээлтээс хойш бидний илрүүлсэн хамгийн чухал эрдэсжсэн бүс болсон.

2020 оны 8-р сард анхны өрөмдлөгийн ажлыг гүйцэтгэснээс хойш Компани нь Хар Морь хэтийн төлөв бүхий талбайд нийт 94 цооног буюу 12,395 метр өрөмдлөг хийсэн нь ойролцоогоор 4.6 км (Зүүн-Баруун) 2.6 км (Хойд-Урд) талбайг хамарсан. Өрөмдлөгийн цооногийн босоо гүн нь 35-аас 292 метрийн хооронд байсан ба дунджаар 110 метр байв. Өнөөдрийн үр дүнг оролцуулан огтлолцлуудын онцлох мэдээлэл:

- 194 метрээс эхлэн 1.74 г/т алтны агуулга бүхий 30 метрийн интервал багтаасан 1.18 г/т алтны агуулга бүхий 48 метрийн интервал (AAD-57)
- 10 метрээс эхлэн 5.97 г/т алтны агуулга бүхий 45 метрийн интервал огтолсон нь 27.07 г/т алтны агуулга бүхий 8 метрийн интервал (AAD-58)
- AAD-58 цооногоос хойд зүгт 500 метр газар байршилд 10 метрээс эхлэн 0.53 г/т алтны агуулга бүхий 130 метрийн интервал (AAD-61).
- 53 метрээс эхлэн 1.31 г/т алтны агуулга бүхий 14 метрийн интервал болон 112 метрээс эхлэн 1.74 г/т алтны агуулга бүхий 20 метрийн интервал (AAD-66)
- 4 метрээс эхлэн 2.65 г/т алтны агуулга бүхий 35 метрийн интервал, үүнд 5.10 г/т алтны агуулга бүхий 12 метр интервал огтолсон (AAD-81)

2021 онд Эрдэнэ Ресурс нь Хар Морь талбайд гурван удаагийн өрөмдлөгийн хөтөлбөр хэрэгжүүлсэн ба үүнд: 2-р сард 1,909 метрийн хайгуулын өрөмдлөг, 3-р сард 3,373 метрийн өрөмдлөгийн хөтөлбөр болон өнөөдрийн танилцуулсан 2,053 метрийн өрөмдлөг багтаж байна. ([2021 оны 6 сарын 15-ны хэвлэлийн мэдээтэй танилцана уу.](#))

Монгол Улс дахь Ковид-19 нөхцөл байдлын тухай

2021 оны 2-р улиралд Монгол Улс дахь Ковид-19-ийн халдварын тохиолдлууд их хэмжээгээр нэмэгдсэн. Үүний улмаас улсын хэмжээнд бараа бүтээгдэхүүн болон иргэдийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоосон. 2021 оны 6-р сарын эцэст Эрдэнэ Ресурсийн үйл ажиллагаа эрхэлдэг Баянхонгор аймаг болон Шинэжинст суманд Ковид-19-ийн халдварын тоо нэмэгдсэнээр хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосон. Компани нь энэхүү хязгаарлалтын дэглэмийн хүрээнд 6 сарын 28-аас эхлэн хайгуулын ажлаа түр хугацаанд зогсоогоод байна. Одоогоор хязгаарлалтуудыг цуцалсан бөгөөд Компанийн ажилтнууд болон гүйцэтгэгч байгууллагууд хайгуулын хөтөлбөрийг үргэлжлүүлэн гүйцэтгэхээр төлөвлөж байна.

Хээрийн үйл ажиллагааг үргэлжлүүлэхтэй холбогдуулан Компани нь Монгол Улс дахь үйл ажиллагаанд өдөр тутмын эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны танилцуулгуудыг хийх, биеийн температур шалгах, эрүүл ахуйн шинэчилсэн протокол ашиглах, түргэвчилсэн оношлуур болон бусад хувийн хамгаалалтын нэмэлт хэрэгслүүдийг ашиглан, хэрэгжүүлж эхэлсэн. Компани нь төслийн талбайд хайгуулын хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаанд шинжилгээ хийх, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны журмыг хэрэгжүүлэн ажиллах чиглэлээр мэргэшсэн сувилагч ажиллуулдаг. Компанийн удирдлага, захиргааны ажилтнууд нь шинэчилсэн хуваарийн дагуу сайжруулсан эрүүл ахуйн арга хэмжээг авч хэрэгжүүлэн, үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэн ажиллаж байна.

Эрдэнэ Ресурсийн Баянхонгор аймагт ажиллаж буй бүх ажилтан болон гэрээт байгууллагын ажилтнууд нь Ковид-ийн эсрэг вакцины бүрэн тунд хамрагдсан. Ажилтан, гэрээт байгууллагын ажилтнууд нь хээрийн кэмпэд ажиллахаас өмнө Ковид-19-ийн шинжилгээ өгч, сөрөг үр дүнтэй байх шаардлагатай бөгөөд хээрийн ангид очсоны дараа түргэвчилсэн оношлуураар шалган, сөрөг үр дүнг баталгаажуулах шаардлагатай. Компани нь эдгээр арга хэмжээг авч хэрэгжүүлснээр төлөвлөсөн хээрийн үйл ажиллагаанд нөлөөлөл үзүүлэхгүй хэмээн итгэж байна.

Хөндий Алтны Дүүргийн тухай

Эрдэнэ Ресурсийн ордууд нь дэлхийн томоохон алт, алт-зэсийн ордуудыг агуулагч Төв Азийн Орогены бүсэд багтдаг Эдрэнгийн терреинд байрладаг. Эрдэнэ Ресурс нь Монгол Улсын баруун өмнөд хэсэгт 10 гаруй жил хайгуул судалгааг хийн, өдгөө Хөндий алтны дүүргийг нээн илрүүлсэн. Хөндий алтны дүүрэг нь өндөр агуулга бүхий алт, полиметаллын хэд хэдэн хэтийн төлөвт талбайг хамардгаас Баян Хөндий, Алтан Нар ордуудыг ашиглалтын шатанд хүртэл хөгжүүлэхээр зорьж байна. Эдгээр ордуудыг хамтад нь Хөндий Алтны Төсөл (“Төсөл”) хэмээн нэрлэдэг. Компани нь түүнээс гадна Хөндий Алтны Дүүргийн зүүн зүгт 30 км-т өөрийн 100% эзэмшлийн Хөвийн Хар тусгай зөвшөөрлийн талбайд томоохон Зуун Мод молибден-зэсийн орд болон хэд хэдэн зэс ба молибденийн порфирийн хэтийн төлөв бүхий бүсүүдийг хөгжүүлж байна.

Баян Хөндийд 3.16 г/т дундаж алтны агуулга бүхий 521,000 унц баттай болон бодитой геологийн нөөц¹ (“Measured and Indicated Resources”)², 3.68 г/т алтны агуулга бүхий 103,000 унц боломжит нөөц (“Inferred Resources”) тодорхойлогдсон. Баттай болон Бодитой нөөцөд 3.7г/т алтны агуулга бүхий 409,000 унц батлагдсан болон магадалсан үйлдвэрлэлийн нөөц (“Proven and Probable Reserve”) багтдаг. (Хэвлэлийн мэдээтэй эндээс танилцана уу) Баттай болон бодитой нөөц, боломжит нөөцийг нэмэгдүүлж, үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэх боломжтой.

2020 оны 7-р сард Эрдэнэ Ресурс нь Баян Хөндий Алтны Төслийн хараат бус нарийвчилсан ТЭЗҮ-ийн үр дүнг танилцуулсан. (Хэвлэлийн мэдээтэй эндээс танилцана уу) Нарийвчилсан ТЭЗҮ-ийн суурь үзүүлэлтээр татварын дараах өнөөгийн цэвэр үнэ цэн (5% хорогдуулалт бүхий) (NPV5%) \$100 сая ам.доллар ба дотоод өгөөжийн түвшин (IRR) 42% тооцоологдсон. Баян Хөндийн нарийвчилсан ТЭЗҮ нь 0-7 жилийн хугацаанд 3.71 г/т алтны дундаж агуулга бүхий, жилд 63,500 унц алт олборлохоор тооцоолсон бөгөөд уламжлалт нүүрстэй уусгах технологиор боловсруулахаар төлөвлөсөн. Төслийн төлөвлөгөөгөөр олборлолтыг 2023 онд эхлүүлнэ.

Эрдэнэ Ресурсийн тухай

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол Улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүртгэлтэй хайгуулын компани. Компани нь Монгол Улсын баруун урд бүсэд 2 хайгуулын, 3 ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын бүсэд хийсэн судалгааны үр дүнд Хөндий Алтны Дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээлэлтэй Компанийн вебсайт www.erdene.com -оос танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээлэл авахыг зөвлөж байна.

Мэргэшсэн этгээд (геологч) ба дээжлэлтийн протокол

Петер Далтон (Peter Dalton) нь Компанийн ахлах геологич (P. Geo, Nova Scotia) бөгөөд NI 43-101-т заасан мэргэшсэн этгээд ба урьдчилсан ТЭЗҮ, АШЭЗТ-оос бусад техникийн мэдээлэл, Баян Хөндийн эрдсийн баялаг, нөөцөөс бусад мэдээ мэдээллийг Эрдэнэ Ресурсийн зүгээс хянан баталгаажуулсан болно. Бүх дээжийг Улаанбаатар хот дахь Эс Жи Эс (“SGS”) лабораторид шинжлүүлсэн. Эс Жи Эс лабораторийн дотоод хяналт шалгалтаас гадна, Компани нь тусгай стандарт бэлдэц, хээрийн болон лабораторийн хуулбар, мөн хүдэржилтгүй бэлдцийг ашиглан дээжийн чанарын хяналт, баталгаажуулалт (“QA/QC”) -ын протоколыг гүйцэтгэсэн. Бүх дээжид алтны агуулгыг стандарт Хайлуулах аргаар (fire assay), бусад 33 химийн

¹ Хөндий алтны төслийн эрдсийн нөөцийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй 2019 оны 12 сарын 4-нд SEDAR-т байршуулсан Тетра Текийн боловсруулсан NI 43-101 техникийн тайлангаас танилцана уу.

² Баттай ба бодит геологийн нөөц: 3.77 г/т алтны агуулга бүхий 171,000 унц баттай нөөц, 2.93 г/т алтны агуулга бүхий 349,700 унц бодит нөөц

элементийг Индукцын хос плазмит спектрометрийн арга (Inductively Coupled Plasma Optical Emission Spectroscopy) ашиглан тогтоосон. 5 г/т алтны агуулгаас дээш агуулга илэрсэн дээжүүдэд алтны шигшүүрийн шинжилгээ (screen-metallic gold analysis) хийсэн ба энэ нь 500 гр дээжний 75 микроноос бага байх 30 гр бүхий 3 дээж болон 75 микроноос том байх хэсгүүдэд хийгдсэн алтны хайлуулах (fire assay) шинжилгээнүүдийн жигнэсэн дунджаар илэрхийлэгддэг.

Эрдэнийн дээжлэлтийн протокол нь (хүдэржилт болон чулуулгийн төрлөөс хамаарч) зарим нэг жижиг, хүдэржилтийн дараа үеийн чулуулаг болон хүдэржилтгүй боржинг алгассан, 1 эсвэл 2 метрийн интервалтайгаар, цооногийг бүтнээр нь хамарсан дээжлэлтээс бүрддэг. Дээжлэлтийн интервалыг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэдэг ба геологийн хяналт эсвэл хүдэржилтээс хамаардаггүй болно. Бүх дээжийг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэн алмазан хөрөөгөөр 2 тэнцүү хуваадаг. Хуваагдсан дээжийн талыг дээжний уутанд ялган авч дээжилдэг бөгөөд үлдсэн талыг нь дээжний хайрцганд үлдээн Компанийн Баян Хөндий дэх хээрийн ангид аюулгүй байдлыг ханган хадгалдаг. Бүх дээжийг нэг багцандаа 30 дээж байхаар хуваарилдаг ба багц болгонд стандарт бэлдэц, хүдэржилтгүй бэлдэц, лабораторийн хуулбар болон хээрийн хуулбар дээж буюу дээжийг 4 хуваан, 2-ыг нь 2 тусад нь дээжлэн Улаанбаатар дахь Эс Жи Эс (“SGS”) лаборатори руу шууд тээвэрлэдэг. Тээвэрлэлтийг Эрдэнэ Ресурсийн ложистикийн гэрээт Монруд ХХК гүйцэтгэдэг.

Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.


ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.

Холбоо барих:


Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон гүйцэтгэх захирал
Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419
И-мэйл: info@erdene.com
Twitter: <https://twitter.com/ErdeneRes>
Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>
LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp-/>



DARK HORSE PROSPECT LOCATION MAP



DARK HORSE EXPLORATION HIGHLIGHTS – 2021



DARK HORSE MANE ZONE PLAN MAP



Legend:

- Drill Collar New (2021 Follow Up)
- Drill Collar (Previous)
- Interpolated Grade Shell
- >1.0 g/t Au
- >0.5 g/t Au
- >0.1 g/t Au

